БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/52НА-СТА-ТШЗ**

Баянхонгор
2022 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Б.Баасанбат
Утас: 96442101 Цахим хаяг: Baasan_bataa@gmail.com
Цахим хуудас: www.audit.mn

## Агуулга


1.Аудитын гэрчилгээ /эх хувь/ ..... 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан ..... 10

3. Аудитын тайлан ..... 10

3.1 Ерөнхий зүйл ..... 10

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 11

3.4 Материаллаг байдал ..... 11

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 12

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 13

3.8 Аудитын гол асуудал ..... 14

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 14

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 14

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 15

4. Аудитын илрүүлэлт ..... 15

**4.1. Төлбөрийн акт** ..... 15

4.2 . Залруулсан алдаа ..... 15

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл** ..... 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/90

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Э.ЦЭРЭНХАНД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **48,833,891.98** | **59,595,646.97** |
| **33** | **АВЛАГА** | 36,000.30 | 1,429,398.29 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 36,000.30 | 1,429,398.29 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 48,797,891.68 | 58,166,248.68 |
| **351** | **Түүхий эд материал** | 6,982,758.68 | 17,899,520.68 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,982,758.68 | 16,261,920.68 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 1,637,600.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 38,610,133.00 | 37,256,728.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,811,575.00 | 1,215,055.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 35,391,058.00 | 34,454,558.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 707,500.00 | 707,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 700,000.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 879,615.00 |
| 35600 | Мал амьтад | 3,205,000.00 | 3,010,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **857,945,950.03** | **848,375,019.30** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 857,945,950.03 | 848,375,019.30 |
| **392** | **Биет хөрөнгө** | 850,819,950.03 | 841,249,019.30 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 864,533,892.00 | 864,533,892.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -36,138,448.50 | -55,457,359.50 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 47,194,546.00 | 58,419,546.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -36,981,470.89 | -38,390,537.58 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,893,562.00 | 31,793,562.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -21,753,145.16 | -23,266,098.20 |
| 39217 | Ном | 3,071,014.58 | 3,616,014.58 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,126,000.00 | 7,126,000.00 |
| 39301 | Програм хангамж | 300,000.00 | 300,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -300,000.00 | -300,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,126,000.00 | 7,126,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **906,779,842.01** | **907,970,666.27** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **906,779,842.01** | **907,970,666.27** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 906,779,842.01 | 907,970,666.27 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 237,571,346.00 | 237,571,346.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 237,571,346.00 | 237,571,346.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 639,565,957.68 | 640,756,781.94 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 639,565,957.68 | 639,565,957.68 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,190,824.26 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 29,642,538.33 | 29,642,538.33 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **906,779,842.01** | **907,970,666.27** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **285,472,900.00** | **305,800,940.24** |

| | | | |
|---|---|---|---|
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **7,873,500.00** | **10,146,162.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 7,873,500.00 | 10,146,162.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,873,500.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 7,873,500.00 | 00.00 |
| **120017** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | **7.871.162.00** |
| **120018** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | **2.275.000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **277,599,400.00** | **295,654,778.24** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 252,284,200.00 | 267,546,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 252,284,200.00 | 267,546,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,213,900.00 | 3,550,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,213900.00 | 3,550,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 20,101,300.00 | 24,557,878.24 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,101,300.00 | 24,557,878.24 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **293,074,513.71** | **304,610,115.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **293,074,513.71** | **304,610,115.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 267,811,403.46 | 283,853,906.03 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 176,482,834.61 | 182,619,520.72 |
| 210101 | Үндсэн цалин | 166,351,648.61 | 182,619,520.72 |
| 210102 | Нэмэгдэл | 10,131,186.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,001,738.01 | 23,646,145.34 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,520,974.57 | 17,042,409.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,766,037.28 | 1,828,979.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,412,831.42 | 1,463,184.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 298,355.34 | 301,051.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,003,539.40 | 3,010,522.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,011,405.93 | 23,834,478.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,690,760.93 | 1,458,465.24 |
| 210302 | Түлш, халаалт | 19,257,100.00 | 22,331,763.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 63,545.00 | 44,250.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,331,693.00 | 12,729,906.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,502,720.00 | 1,063,820.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,420,323.00 | 2,022,166.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,225,200.00 | 1,511,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 374,500.00 | 131,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,778,950.00 | 4,708,720.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 30,000.00 | 87,400.00 |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | 00.00 | 3,205,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 17,187,425.00 | 11,800,475.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 136,500.00 | 361,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,050,925.00 | 11,438,675.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 425,000.00 | 1,492,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 150,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 425,000.00 | 1,342,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,338,100.00 | 509,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,338,100.00 | 509,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 778,000.00 | 4,230,850.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 528,000.00 | 3,880,850.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 350,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,255,206.91 | 22,990,930.73 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 223,000.00 | 750,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 22,032,206.91 | 22,240,930.73 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 25,263,110.25 | 20,756,209.95 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,297,600.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,213,900.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 83,700.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 525,284.07 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 525,284.07 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 19,440,226.18 | 20,756,209.95 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,440,226.18 | 20,756,209.95 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-7,601,613.71** | **1,190,824.26** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-7,601,613.71** | **1,190,824.26** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **277,599,400.00** | **295,654,778.24** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **277,599,400.00** | **295,654,778.24** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 252,284,200.00 | 267,546,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 252,284,200.00 | 267,546,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,213,900.00 | 3,550,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,213,900.00 | 3,550,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 20,101,300.00 | 24,557,878.24 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,101,300.00 | 24,557,878.24 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **277,394,400.00** | **285,259,778.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **277,394,400.00** | **285,259,778.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **252,131,289.75** | **264,503,568.29** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 175,336,750.82 | 176,288,564.05 |
| 210101 | Үндсэн цалин | 126,226,656.09 | 140,183,674.02 |
| 210102 | Нэмэгдэл | 20,458,188.72 | 16,014,097.84 |
| 210104 | Урамшуулал | 21,268,934.75 | 20,090,792.19 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,382,971.26 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 24,278,800.00 | 31,370,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,509,600.00 | 22,137,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,942,300.00 | 2,308,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,553,800.00 | 1,846,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 388,500.00 | 461,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,884,600.00 | 4,616,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,576,015.93 | 24,057,878.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,690,760.93 | 1,556,478.24 |
| 210302 | Түлш, халаалт | 17,590,550.00 | 22,233,750.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 294,705.00 | 267,650.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,224,273.00 | 6,945,766.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 75,300.00 | 183,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,499,873.00 | 1,989,966.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,368,200.00 | 1,293,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 121,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 424,500.00 | 207,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 856,400.00 | 3,151,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 21,365,650.00 | 17,742,910.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,839,100.00 | 2,023,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,991,550.00 | 12,374,510.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,535,000.00 | 3,345,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,125,000.00 | 1,965,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,000,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 1,323,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,125,000.00 | 642,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,338,100.00 | 509,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,338,100.00 | 509,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,049,700.00 | 4,652,050.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 799,700.00 | 4,062,050.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,837,000.00 | 971,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,837,000.00 | 971,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **25,263,110.25** | **20,756,209.95** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,297,600.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,213,900.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 83,700.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 525,284.07 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 525,284.07 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 19,440,226.18 | 20,756,209.95 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,440,226.18 | 20,756,209.95 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **205,000.00** | **10,395,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **205,000.00** | **10,395,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **205,000.00** | **10,395,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 205,000.00 | 10,395,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 205,000.00 | 10,395,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-205,000.00** | **-10,395,000.00** |
| **7** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.00** | **0.00** |
| **8** | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | **0.00** | **0.00** |
| **9** | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **0.00** | **0.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| С01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 230,445,346.00 | 29,642,538.33 | 706,532,558.51 | 00.00 | **966,620,442.84** |
| С03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **230,445,346.00** | **29,642,538.33** | **706,532,558.51** | **00.00** | **966,620,442.84** |
| С07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 24,957,155.90 | 00.00 | **24,957,155.90** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **237,571,346.00** | **29,642,538.33** | **639,565,957.68** | **00.00** | **906,779,842.01** |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **237,571,346.00** | **29,642,538.33** | **639,565,957.68** | **00.00** | **906,779,842.01** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **237,571,346.00** | **29,642,538.33** | **639,565,957.68** | **00.00** | **906,779,842.01** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,190,824.26 | 00.00 | **1,190,824.26** |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **237,571,346.00** | **29,642,538.33** | **640,756,781.94** | **00.00** | **907,970,666.27** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 298,995,900.00 | 271,347,768.29 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 298,995,900.00 | 271,347,768.29 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 298,903,000.00 | 271,347,768.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 192,245,900.00 | 176,288,564.05 |
| 210101 | Үндсэн цалин | 144,520,300.00 | 140,183,674.02 |
| 210102 | Нэмэгдэл | 19,621,100.00 | 16,014,097.84 |
| 210104 | Урамшуулал | 28,104,500.00 | 20,090,792.19 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,370,500.00 | 31,370,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,137,600.00 | 22,137,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,308,200.00 | 2,308,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,846,600.00 | 1,846,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 461,600.00 | 461,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,616,500.00 | 4,616,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,949,800.00 | 24,057,878.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,470,300.00 | 1,556,478.24 |
| 210302 | Түлш, халаалт | 27,179,500.00 | 22,233,750.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 267,650.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,264,400.00 | 7,171,266.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 183,600.00 | 183,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,000,000.00 | 1,989,966.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,374,900.00 | 1,293,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 346,500.00 | 346,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 207,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,119,400.00 | 3,151,000.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 22,113,500.00 | 17,742,910.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,023,400.00 | 2,023,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,673,600.00 | 12,374,510.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,416,500.00 | 3,345,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,642,500.00 | 8,465,400.00 |
| 210602 | Тавилга | 8,000,000.00 | 7,823,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 642,500.00 | 642,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 536,700.00 | 509,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 536,700.00 | 509,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,410,900.00 | 1,401,250.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 820,900.00 | 811,250.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4368800.00 | 4340800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,368,800.00 | 4,340,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 92900.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 92,900.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 92,900.00 | 00.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 298,995,900.00 | 271,347,768.29 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 267,546,100.00 | 246,789,890.05 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 267,546,100.00 | 246,789,890.05 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 31,449,800.00 | 24,557,878.24 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 31,449,800.00 | 24,557,878.24 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 18.00 | 18.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 13.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 04.00 | 04.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,213,900.00** | **3,550,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,213,900.00** | **3,550,800.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,213,900.00 | 3550800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,213,900.00 | 3,550,800.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,213,900.00 | 3,550,800.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 5,213,900.00 | 3,550,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,213,900.00 | 3,550,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,213,900.00 | 3,550,800.00 |
| 8 | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | **0.00** | **0.00** |
| 9 | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **0.00** | **0.00** |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын

талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цэзням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын Цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Цэцэрлэгийн эрхлэгч Э.Цэрэнханд нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Ж.Дорждавга нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гурванбулаг сумын Цэцэрлэг нь мэргэжлийн ур чадвартай боловсон хүчнээр хангагдах, хүүхэд хөгжих таатай орчин бүрдүүлэн, хүүхэд бүрийг хөгжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь салбарын хэмжээнд мөрдөх холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 293,074.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,396.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,297.1мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 3,426.8 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 907,970.7 мянган төгрөг болж өмнөх оноос 1,190.8 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 48,833.9 | 59,595.6 | 10,761.8 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 36.0 | 1,429.4 | 1,393.4 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 48,797.9 | 58,166.2 | 9,368.4 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 857,946.0 | 848,375.0 | (9,570.9) |
| Үндсэн хөрөнгө | 953,119.0 | 965,789.0 | 12,670.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (95,173.1) | (117,414.0) | (22,240.9) |
| **Нийт хөрөнгө** | 906,779.8 | 907,970.7 | 1,190.8 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 906,779.8 | 907,970.7 | 1,190.8 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 906,779.8 | 907,970.7 | 1,190.8 |

Эх сурвалж:2021 оны санхүүгийн тайлангаас

Бараа материалын дансны үлдэгдэл 58,166.2 мянган төгрөг болж 9,368.4 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 9,279.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Авлага дансны үлдэгдэл 1,429.4 мянган төгрөг болж өмнөх оноос өссөн нь ХХОАТ-ын 2021 оны 12 дугаар сарын төлөлтийн гүйлгээг төсвөөс 2 дахин хийж, илүү төлөлт хийсэнтэй холбоотой .

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 965,789.0 мянган төгрөг болж 12,670.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 8,950.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, 900.0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил, 545.0 мянган төгрөгөөр ном худалдан авсан.

Мөн БСШУЯамнаас 2,275.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэгүй шилжүүлж авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 907,970.7 мянган төгрөг болж өмнөх оноос 1,190.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 3,550.8 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 397,315.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 397,315.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 25,300.0 мянган төгрөгөөр бууруулж 372,015.1 мянган төгрөгөөр батлагдсан ба аймгийн Засаг даргын 2021.05.06-ний А/289 тоот, 2021.12.06-ны А/742 тоот захирамжуудаар төсвийн зохицуулалт хийгдэж 298,995.9 мянган төрөг болж 73,019.2 мянган төгрөг буюу 19,6 хувиар буурч батлагдсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 298,995.9 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 267,546.1 мянга, орон нутгийн төсвөөс 31,449.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 267,546.1 мянга, орон нутгийн төсвөөс 24,557.8 мянга нийт 292,103.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 271,347.8 мянган төгрөгийг зарцуулж 20,756.2 мянган төгрөг буюу 7,1 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 6,891.9 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 271,347.8 мянган төгрөг буюу 90,8 хувьтай байгаа нь нормативд зардлыг 4,370.6 мянган төгрөг, цалингийн зардлыг 15,957.3 мянган төгрөг, тогтмол зардлыг 6,891.9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 3,550.8 мянган төгрөгийг зохих журмын дагуу зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Глобал аудит" ХХК –ний аудитор Б.Баасанбат санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 25 ажил төлөвлөснөөс биелэлт 97 хувьтай хэрэгжсэн.

**3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 304,610.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 11,535.6 мянган төгрөгөөр буюу 3,9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, НДШ-ийн зардал хангамж, бараа материалын зардал өсөж, нормативд зардал буурсан үзүүлэлттэй байна.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл , мэдээлбэл зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

**3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 30,949.8 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 6,189.9 мянган төгрөг байна. Төсвийн гүйцэтгэлээр 6,891.9 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байгаа нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын "1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалттай нийцэж байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 25,352.9 мянган төгрөгийн хүүхдийн хоол худалдан авах ажиллагааг сумын ЗДТГ зохион байгуулсан байна .

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байх зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 2434.4 мянган төгрөгийн 2 зөрчил илэрч, 1429.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1005.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулав.

**4.1. Төлбөрийн акт**

**4.1.1**. Ажиллагсдын цалингаас суутгасан ХХОАТ-ын 1429.4 мянган төгрөгийг төсвөөс илүү төлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. Санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**:Төсвөөс илүү төлсөн 1429.4 мянган төгрөгийн авлагыг хоорондын тооцоогоор суутган тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**4.2 . Залруулсан алдаа .**

**4.2.1.** Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1005.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг НББ-д орлого авч үлдэгдлээр тусгасан байхад нярвын тайланд орлого аваагүй, тооллогоор үлдэгдлээр тоологдсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, санхүүгийн тайлангийн " Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь** : Нярвын тайланг 1005.0 мянган төгрөгөөр залруулж тайланг гаргуулав.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Гурванбулаг сумын Цэцэрлэг | 2 | 2434.4 | 1 | 1005.0 | 1 | 1429.4 | 0 | 0,0 | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

______оОо______

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2022 оны 02 сарын 25 өдөр Дугаар НО/А01442525 БНА/2022/52/НА-СТА-ТЗШ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажиллагсдын цалингаас суутгасан ХХОАТ-ын 1,429.398 төгрөгийг төсвөөс илүү төлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ХХОАТ-ын илүү төлсөн 1,429,398.0 /Нэг сая дөрвөн зуун хорин есөн мянга гурван зуун ерэн найман/ төгрөгийн авлагыг хоорондын тооцоогоор суутган тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов. ажилтнаар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх[1]

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2022 оны 05 дугээр сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

D:\Акт.docx
005050081

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Цэцэрлэгийн эрхлэгч Э.Цэрэнхандад хариуцуулав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТОР: Б.БААСАНБАТ

---

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно